

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг /2/

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-7</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>4-4</i>
<i>2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>	<i>4-7</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 15-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл- /2/**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар;

Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Ш.Раднаасэд.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Хүн амын хөгжлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Жавзанжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Н.Мөнхзэсэм, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, Тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсөв судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Н.Мөнхзэсэм, Ё.Энхсайхан мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт гаргасан саналаа татан авч, үг хэлэв.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Тогтоолын төсөлд Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналыг нэмж тусган батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
18 цаг 21 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны хуралдаанд нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна. Өнөөдрийн хуралдааныг үргэлжлүүлье. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг дахиад танилцуулъя.

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд. Эцсийн хэлэлцүүлэг байгаа.

2.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд 3 дахь хэлэлцүүлэг байна. Ингээд хэлэлцэх асуудалд орцгооё.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг түрүүн танилцуулсан байгаа.

Хууль, тогтоолуудын эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүдийг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Дагалдах хуулиуд байна. Алга байна. Ингээд хууль,

тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гаргах танилцуулгыг би танилцуулъя. Миний бие өөрөө танилцуулчихъя.

Ингээд хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

18.24 цаг.

2 дахь асуудал. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн мөн адил. Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган эцсийн хувилбарыг танилцуулгын хамтаар та бүхэнд тараасан байгаа. Ингээд эцсийн хувилбарын төсөл болон танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Сандаг-Очир гишүүнээ тэгэхээр тодорхой саналтай байна. Горимын санал байна. Зарчмын зөрөөтэй санал байна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: 2 дугаар хэлэлцүүлэг дээр төсвийг дагаад Шадар сайдын ажлын албанаас намайг Төсвийн байнгын хороонд байдаг гишүүний хувьд энэ төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын зохицуулалтыг хийх зорилгоор ийм зарчмын зөрүүтэй саналыг гаргаж өгөөч гэдэг ийм саналыг тавьсан. Ямар нэгэн төсвийн урсгал зардал нэмэгдүүлж байгаа зүйл байхгүй. Зөвхөн зохицуулалт хийж байгаа гэсэн. Тэгээд энийг нь гаргасан. Тэгээд энэ нь бас одоо сая судлуулахад бол бас 1,6 тэрбум нь 1 тэрбум нь урсгал зардлаас хөрөнгө

оруулалтын шинж чанартай зардал байна. Тийм учраас шилжүүлж болохгүй гэдэг ийм саналыг бас хэлж байна. Тийм учраас бас гаргасан саналаа ... Жавхлан сайд бас судлаад танилцуулж байна. Зарчмын хувьд хууль зөрчинө. Болохгүй. Зардал одоо зохицуулалт биш, урсгал зардлаас хөрөнгө оруулалт хийж болохгүй. Тийм учраас ажлын албанаас тавьсан зарчмын зөрүүтэй саналаа татаж авч байна. Нөгөө талаар бас Засгийн газрын гишүүдийг танхимын зарчмыг алдагдуулж буруу зөрүү ойлголт гаргасан бол уучлаарай гэж хэлье. Тэгээд гаргасан саналыг хууль зөрчиж байгаа санал байна гэж үзээд гаргасан саналыг зарчмын хувьд татаж авч байна.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Тэгээд Сандаг-Очир гишүүний гаргасан саналыг протоколд тусгаж авлаа. Ингээд эцсийн хувилбарын төсөл болон танилцуулгатай холбогдуулан гишүүд үг хэлж, байр сууриа илэрхийлж дууслаа.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 2 дугаар хэлэлцүүлгээр одоо бас ингээд Төсвийн тодотгол маань дэмжигдсэн тэй холбогдуулаад хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг бол Байнгын хорооноос санаачлах санаачилгыг гаргаж байна. Сая та бүхэнд Төсвийн байнгын хороон дээр. Та бүхэнд эхлээд би уншаад танилцуулчихъя. Гишүүдэд одоо хэвлээд тараах гэж байна.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг. Энийг групп дээр тавиарай. Байнгын хорооны групп дээр тавьсан уу. Гишүүд түр хэвлэгдэж ирэх хүртэл харж байгаарай. Бас утсаараа давхар.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг, 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол банк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай.

1/Үнийн өсөлтөөс сэргийлэх инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах, цаашид бууруулах,

2/Төлбөрийн тэнцлийг сайжруулах, инфляцыг бууруулахад чиглэсэн төсөв мөнгөний бодлогын тохиргоог тухай бүр авч хэрэгжүүлэх,

3/Валютын цэвэр дотогшилох урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр экспортыг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, импортын орц их шаарддаг томоохон төсөл арга хэмжээг төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийг харгалзан хэрэгжүүлэх,

4/Хүнсний бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийн хангалтыг харгалзан татварын уян хатан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг авах,

5/Төрөөс хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах чиглэлээр аж ахуйн нэгжүүдэд олгодог хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгийг хэрхэн оновчтой хуваарилах, төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн талаар мэдээлэл судалгааг гаргаж цаашид авах

арга хэмжээний талаарх санал, дүгнэлт боловсруулах.

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

1/Төрийн албан хаагчийн цалин хөлс, албан тушаалын цалингийн хэмжээ сүлжээг зохицуулж байгаа холбогдох хууль тогтоомжийг Төрийн албаны тухай хуулийн 4.7 дахь хэсэгтэй нийцүүлэн 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө өөрчлөх саналыг боловсруулж шийдвэрлүүлэх,

Гурав.Энэ тогтоолын хэрэгжилт үр дүнгийн тайланг 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол банк /Б.Лхагвасүрэн/-д, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-т тус тус үүрэг болгосугай.

Энэ тогтоолыг 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл боловсруулсан байгаа. Гишүүдэд хэвлэгдэж тараагдаж амжсан уу. Ирсэн байгаа, гишүүдэд өгсөн байгаа тээ.

Гишүүд тогтоолын төсөлтэй холбогдуулж саналаа хэлж болно. Саналтай, үг хэлэх гишүүд байна уу. Асуулттай гишүүд байна уу. Батжаргал гишүүн. Батжаргал гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Ж.Батжаргал: Тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Тэгэхээр зэрэг харин нэг юун дотор 2

дахин даалгасан заалт орох юм уу, эс үгүй бол тэр 1 дүгээр заалтдаа 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон дагалдан батлагдсан одоо дагалдан гарсан хуулиуд батлагдсантай холбогдуулан гэж хэлээд, тэгээд одоо тэр 2.1 дэх болоод байгаа хэсгээ 6 болгож оруулаад бүтцийнх нь хувьд ингээд өөрчилчихвөл яасан юм л гэсэн санаа байна. Тэртээ тэргүй өөр өөрийнхөө заалтаар л хамаарагдана шүү дээ. Одоо тэр 1.4 дэх заалт чинь Монголбанканд ямар хамаатай юм. Угаасаа ялгаагүй л юм чинь.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Сандаг-Очир гишүүн саналаа хэлье.

Ц.Сандаг-Очир: Би ч гэсэн бас энэ 1 дэх заалт, 5 дахь заалт 2 гээд бас л үнийн өсөлтөөс сэргийлэх 5 дээрээ бас төрөөс хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах чиглэлээр гээд. Ер нь тэгээд яг энэ үнийн өсөлтийг тогтворжуулж гэдэг юм уу, сэргийлж чадах юм уу. Ер нь бол зах зээлийн харилцаанд эдийн засгийн харилцаанд ер нь бололцоо боломж нь байгаа юм уу. Энэ үнийг одоо хатуу зохицуулалттай гэдэг юм уу, хатуу барьж чадах юм уу. Тэгээд энэ чинь нэг цаасан дээр үлдсэн хоосон хэрэгждэггүй шийдвэрийн нэг болж хувирах вий дээ. Хасъя гэсэн үү. Харин тийм, энэ 2 чинь 1 дэх, 5 дахь 2 чинь ерөнхийдөө 1 агуулгатай болчихоод байна шүү дээ. Хоёулаа л гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг өсөлтөөс сэргийлэх л юм яригдаад байна шүү дээ. Тэр байна аа. Өөр алга.

Г.Тэмүүлэн: 1, 5 2 болохоор яах вэ, агуулгын хувьд арай өөр болчихоод байгаа юм. 5 нь бол нөгөө Засгийн газраас энэ бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулахтай холбоотой одоог хүртэл хэрэгжүүлсэн гэдэг юм уу, эсвэл түүн дээрээ судалгаа гаргаад, цаашид авч хэрэгжүүлэх гэдэг юм уу, алдаа оноогоо дүгнэж, бас арай цэгцлэх

ийм бодлогыг гаргаж ирж оруулж ирээч л гэсэн санал байгаад байгаа юм.

хорооны гишүүд болон ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Нэг дэх нь бол ерөнхий ийм үнийн өсөлтөөс сэргийлэх, инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах, цаашид бууруулах гэдэг юм уу ийм малгай өгүүлбэр юу л байна гэж бодоод байгаа юм. Хэрэв та яана гэж байвал, бүр болохгүй бол нэгийг бол дээшийгээ нөгөө малгай 1 дүгээр заалт дээрээ нэмж бас холбож болно. Ерөнхий үндсэн том тогтоолынх нь агуулга нь тэр учраас. Тэгээд хоёроосоо 1 гэж явж болно. Тэгэх үү. Тэгвэл ерөөсөө ингэе дээ. Сая түрүүн Батжаргал гишүүний гаргасан саналаар 2 дахь заалтыг нь дээшийгээ 1 дэх заалттай нэгтгээд дараагийн 2.1 гэснийгээ 6 болгоод л тэгээд нийтдээ 6 заалттайгаар л ингээд батлаад явъя тэгэх үү. Тэгье. Үг, үсэг өөр найруулга дээр өөр анхаарах үг үсгүүд байна уу. Янзлах барих. Ингээд болж байна гэвэл саяын та бүхний хэлсэн саналын хүрээнд тогтоолын төслийг бас ингээд групп дээр тавиад, тэгээд төсөвтэйгөө баталъя. Зарчмыг дэмжье гэсэн саналаар. Тэгвэл тэгээд төсвийн тодотголыг дагалдаж гарах Улсын Их Хурлын тогтоолын төслийг саяын гишүүдийн хэлсэн саналын хүрээнд баталъя гэсэн зарчмын хувьд бол саяны саналыг нэгтгээд дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 72,7 хувиар дэмжигдлээ.

Гишүүддээ баярлалаа. Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганд миний бие өөрөө танилцуулъя. Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Байнгын

18.36 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ